



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.14 № 01/06 ДУА-2017/102/СТА - ТЧ/3

САЙХАН-ОВОО СУМЫН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Д.САРНАЙ ТАНАА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Цэцэрлэгийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт олгоходоо 135,000.00 /Нэг зуун гучин таван мянга/ төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутгалгүй илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1-т /Дараах хөдөлморийн холс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна/, 32.1.4-т /аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлогол/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжсуулэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-т /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ заасан заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Илүү тооцож олгосон 135,000.00 /Нэг зуун гучин таван мянга/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаас суутган тооцож, Сайхан-Овоо сумын Цэцэрлэгийн Төрийн сан банк дахь **100081215201** тоот дансанд 2017 оны 04 дүгээр сарын 05-ны дотор төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Сарнай, нягтлан бодогч Г.Бум-Аюуш нарт хариуцуулав.

**АКТЫГ**

**ТОГТООСОН<sup>1</sup>:**

ШИНЖЭЭЧ

Ж.УГТАХБАЯР

**ЗӨВШӨӨРСӨН:**

САЙХАН ОВОО

ДАРГА

Д.САРНАЙ

НЯГТЛАН БОДОГЧ

Г.БУМ-АЮУШ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.